

## ОЮУТАН ЗАЛУУСЫГ ЦАГИЙН БОЛОН ТҮР АЖЛЫН БАЙРАНД ЗУУЧЛАХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨР

### ЗОРИЛГО:

Оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах, ажлын байраа хадгалах, дадлагажих, төгсөөд ажлын байраар хангагдахад зарцуулагдах хугацааг ойртуулах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хичээлийн бус цагаараа ажил хөдөлмөр эрхлэх, хууль эрх зүйн орчныг бий болгох боломж нөхцлийг бүрдүүлэхэд оршино. Хөтөлбөрийн товчоон:

Манай улсын суурин хүн амын 21,7 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байгаа ба тэдгээрийн 28,1 хувь буюу 175,0 мянга нь төрийн ба төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллеж, МСҮТ-дэд суралцаж байна. Хөдөлмөрийн яам, Нийслэлийн Хөдөлмөрийн газраас оюутнуудын өдөр тутмын хэрэглээгээ хангах, хөдөлмөрт бэлтгэх, нийгэмд өөрийн гэсэн байр суурьтай болох, төлөвших, ажлын байранд дадлагажих зэрэг эдийн засаг, нийгмийн хэрэгцээ нэмэгдэж байгаатай уялдуулан оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 2009 оноос тодорхой төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр байна.

2009-2012 он-“Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын дэд хөтөлбөр”  
Оюутны хөдөлмөрийн бирж

2013 он- “Оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр”

2014 он- “Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил”

2015 он- “Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд оюутан залуусыг цагийн болон түр ажлын байранд зуучлах арга хэмжээг тус тус хэрэгжүүлсээр байна.

Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд 100 гаруй мянган оюутанд хөдөлмөрийн зах зээлийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, 70 мянган оюутныг цагийн ажлын байранд зуучилсны зэрэгцээ үйлдвэрлэлийн шинэ техник, технологитой танилцах дадлагын ажилд оролцсон 5.3 мянган оюутанд дэмжлэг үзүүлсэн нь төгсөгчдийг богино хугацаанд эзэмшсэн мэргэжлээр ажиллах, зах зээлд бие даан өрсөлдөх ур чадварыг нь дээшлүүлэхэд зохих нөлөө үзүүлсэн байна.

Хөдөлмөрийн яам, Нийслэлийн хөдөлмөрийн газраас 2014 онд “ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ЦАГИЙН АЖИЛ” хөтөлбөрийн хүрээнд оюутнуудын хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрт бэлтгэгдэх, дадлагажих, төгсөөд ажлын байраар хангагдах мөн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор 80 их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ын дэргэд “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” байгуулж, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах техник тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгсөн.

2015 онд дээрх төвүүдийн үйл ажиллагааг тогтворжуулан ажиллахаар зорилт тавин ажиллаж байна.

**ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРҮҮД- НЭРШИЛ ЖИЛЭЭР**

- 2009 ОН - “ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУРШИЛТЫН ДЭД ХӨТӨЛБӨР”

- 2010 ОН - “ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУРШИЛТЫН ДЭД ХӨТӨЛБӨР”
- 2011 ОН - “ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУРШИЛТЫН ДЭД ХӨТӨЛБӨР”
- 2012 ОН - “ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУРШИЛТЫН ДЭД ХӨТӨЛБӨР”
- 2013 ОН - “ОЮУТАН ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨР”
- 2014 ОН - “ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ЦАГИЙН АЖИЛ ХӨТӨЛБӨР”
- 2015 ОН - ЗАЛУУЧУУД, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ОЮУТАН ЗАЛУУСЫГ ЦАГИЙН БОЛОН ТҮР АЖЛЫН БАЙРАНД ЗУУЧЛАХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАЖ БАЙНА.